



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХОА-2025/040/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Балжинням Утас: 99435309 Цахим хаяг: baljinnyamd@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.24 № 1/46  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЖАРГАЛАНТ СУМЫН 2-Р  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Т.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.3, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөөт төвлөрүүлж тайлан баланст тусгаагүй 6,662.7 мянга,
- Сүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн санхүүжилтээс хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй 12,120.5 мянга
- Санхүүгийн тайланд тусгаадаагүй өр санхүүжүүлж төлсөн, тооцоо нийлсэн акт баримт байхгүй 64,876.7 мянга,
- Ажилчдаас суутгаасан хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлсөн 13,383.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

### Асуудлыг онцолсон хэсэг

Жаргалант сумын 2-р сургууль нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 78,858.8 мянга, улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 87,579.4 мянга, Боловсролын газраас сурах,

хичээлийн хэрэглэгдэхүүнд 14,479.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж багш, сурагчдын ажиллах, суралцах нөхцөл сайжирсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад заалны түрээсийн орлого 6,662.7 мянган төгрөгийг тайланд тусгалгүй бэлнээр авч зарцуулсан нь материаллаг шинж чанарыг агуулсан болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 бүлэг 19 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>252,877,008.15</u></b>	<b><u>273,824,124.42</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	144,399,978.39	119,204,664.55
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	144,399,978.39	119,204,664.55
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	144,399,978.39	119,204,664.55
31211	Төрийн сангийн харилцах	144,399,978.39	119,204,664.55
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,647,618.00	14,964,333.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,047,618.00	14,873,307.48
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	600,000.00	91,026.00
3351	Байгууллагаас авах авлага	600,000.00	91,026.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	300,000.00	-
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	300,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	300,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	106,529,411.76	126,138,978.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,396,000.00	905,000.00
35130	Эм боох материал	1,396,000.00	905,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	105,133,411.76	125,233,978.96
35410	Бичиг хэргийн материал	305,000.00	261,640.00
35420	Аж ахуйн материал	75,121,108.28	89,639,764.28
35430	Сэлбэг хэрэгсэл	157,500.00	2,628,500.00
35440	Түлш, шатах тослох материал	13,873,720.00	13,873,720.00
35460	Хүнсний материал	-	2,679,271.20
35470	Бусад хангамжийн материал	15,676,083.48	16,151,083.48
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	13,516,147.43
36100	Барааны нөөц	-	13,516,147.43
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,922,019,779.56</u></b>	<b><u>2,914,630,363.50</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,922,019,779.56	2,914,630,363.50
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,527,279,779.56	2,519,890,363.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,678,180,547.25	2,678,180,547.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(404,963,851.76)	(494,277,247.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	421,038,820.60	558,989,981.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(263,108,268.37)	(322,379,176.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	190,924,990.68	218,386,034.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(145,518,891.79)	(168,585,327.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,726,432.95	51,752,432.95
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,176,881.84)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	394,740,000.00	394,740,000.00
39301	Програм хангамж	2,409,948.00	2,409,948.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,409,948.00)	(2,409,948.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	394,740,000.00	394,740,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,174,896,787.71</u></b>	<b><u>3,188,454,487.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>186,373.15</u></b>	<b><u>26,550,500.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	186,373.15	26,550,500.00

<b>413</b>	<b>Өглөг</b>	186,373.15	26,550,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	145,373.15	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	26,509,500.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	41,000.00	41,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	41,000.00	41,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,174,710,414.56</b>	<b>3,161,903,987.92</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,174,710,414.56	3,148,687,840.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,181,249,010.00	1,181,249,010.00
51101	Өмч: - төрийн	1,181,249,010.00	1,181,249,010.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	195,689,490.31	169,666,916.24
51210	Өмнөх үеийн үр дүн	195,689,490.31	195,689,490.31
51220	Тайлант үеийн үр дүн	-	(26,022,574.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,797,771,914.25	1,797,771,914.25
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,174,896,787.71</b>	<b>3,188,454,487.92</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,622,107,154.00</b>	<b>3,310,455,052.23</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,508,306.00</b>	<b>106,745,552.23</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	49,608,306.00	106,745,552.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,484,606.00	102,055,552.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,484,606.00	102,055,552.23
120005	Түрээсийн орлого	2,123,700.00	4,690,000.00
120009	Бусад орлого	-	-
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	9,900,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	9,900,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,562,598,848.00</b>	<b>3,203,709,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	2,849,061,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,849,061,400.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,301,420,548.00	28,052,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,300,769,900.00	28,052,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	650,648.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	261,178,300.00	326,595,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,178,300.00	326,595,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,471,791,471.30</b>	<b>3,336,477,626.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,471,791,471.30</b>	<b>3,336,477,626.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,370,335,355.30	3,220,024,519.82

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,732,298,320.00	2,304,312,374.00
210101	Үндсэн цалин	1,133,623,775.00	1,476,886,667.00
210102	Нэмэгдэл	473,176,230.00	719,556,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,315,000.00	-
210104	Урамшуулал	57,183,315.00	107,868,770.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	215,425,375.32	283,081,542.99
210201	Тэтгэврийн даатгал	148,883,027.21	195,916,668.33
210202	Тэтгэмжийн даатгал	17,405,003.20	23,274,069.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,924,002.55	11,663,113.09
210204	Ажилгүйдлийн даатгал	3,201,212.94	10,445,538.39
210205	Эрүүл мэндийн даатгал	32,012,129.42	41,782,153.42
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	248,717,840.00	309,470,961.52
210301	Гэрэл, цахилгаан	6,973,084.00	11,490,734.52
210302	Түлш, халаалт	197,744,616.00	248,136,000.00
210303	Цэвэр, бохир ус	44,000,140.00	49,844,227.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,232,507.78	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	320,000.00
210408	Бараа материал акталсны зардал	20,232,507.78	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,382,155.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,382,155.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,100,000.00	-
210604	Урсгал засвар	5,100,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,675,300.00	68,522,832.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	627,700.00	30,403,518.23
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,047,600.00	38,119,314.47
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	135,503,857.20	254,316,808.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,130,900.00	60,117,587.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,494,315.00	21,633,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,878,642.20	172,566,120.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	101,456,116.00	116,453,106.48
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,557,100.00	109,128,068.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,557,100.00	109,128,068.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	7,325,038.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,325,038.48
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	899,016.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	899,016.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>150,315,682.70</b>	<b>(26,022,574.07)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>150,315,682.70</b>	<b>(26,022,574.07)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,181,249,010.00	1,797,771,914.25	195,689,490.31	3,174,710,414.56
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,181,249,010.00	1,797,771,914.25	195,689,490.31	3,174,710,414.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,249,010.00	1,797,771,914.25	195,689,490.31	3,174,710,414.56
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(26,022,574.07)	(26,022,574.07)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,181,249,010.00</b>	<b>1,797,771,914.25</b>	<b>169,666,916.24</b>	<b>3,148,687,840.49</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,564,722,548.00</u></b>	<b><u>3,283,178,580.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,123,700.00</b>	<b>10,083,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,123,700.00	10,083,000.00
120005	Түрээсийн орлого	2,123,700.00	4,690,000.00
120009	Бусад орлого	-	5,393,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,562,598,848.00</b>	<b>3,273,095,580.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	2,849,061,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,849,061,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,301,420,548.00	97,438,680.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,300,769,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	650,648.00	97,438,680.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	261,178,300.00	326,595,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	261,178,300.00	326,595,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,428,834,999.61</u></b>	<b><u>3,308,373,893.84</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,428,834,999.61</b>	<b>3,308,373,893.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,327,378,883.61</b>	<b>3,186,446,055.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,670,642,286.61	2,312,977,805.62
210101	Үндсэн цалин	1,189,093,525.19	1,404,152,353.62
210102	Нэмэгдэл	408,055,636.15	750,006,415.00
210104	Урамшуулал	73,493,125.27	157,289,237.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,529,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	278,913,313.00	288,444,400.00
210201	Тэтгэврийн даатгал	207,262,613.00	197,257,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,912,400.00	23,206,800.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	14,330,000.00	11,603,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,582,600.00	11,220,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,825,700.00	45,155,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	248,717,840.00	309,470,961.52
210301	Гэрэл, цахилгаан	6,973,084.00	11,490,734.52
210302	Түлш, халаалт	197,744,616.00	248,136,000.00
210303	Цэвэр, бохир ус	44,000,140.00	49,844,227.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	320,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,561,444.00	9,799,500.00
210604	Урсгал засвар	11,561,444.00	9,799,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,221,300.00	129,947,276.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	627,700.00	83,578,162.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,593,600.00	46,369,114.47
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	104,322,700.00	135,486,111.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,432,300.00	113,745,011.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,890,400.00	21,741,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>101,456,116.00</b>	<b>121,927,838.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,557,100.00	114,602,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,557,100.00	114,602,800.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	7,325,038.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,325,038.48
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	899,016.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	899,016.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>135,887,548.39</u></b>	<b><u>(25,195,313.84)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>999,900.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>999,900.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	999,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	999,900.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(999,900.00)</u></b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	134,887,648.39	(25,195,313.84)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		144,399,978.39
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	144,399,978.39	119,204,664.55

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

ХОА-2024/040/НА-СТА-ТШЗ

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,440,400,100.00	3,193,527,175.84
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,440,400,100.00	3,193,527,175.84
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,320,720,700.00	3,078,924,375.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,383,390,100.00	2,312,977,805.62
210101	Үндсэн цалин	1,634,448,900.00	1,404,152,353.62
210102	Нэмэгдэл	669,016,500.00	750,006,415.00
210104	Урамшуулал	79,924,700.00	157,289,237.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,529,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	297,923,900.00	288,444,400.00
210201	Тэтгэврийн даатгал	202,588,200.00	197,257,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	23,833,900.00	23,206,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,917,000.00	11,603,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,917,000.00	11,220,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	47,667,800.00	45,155,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	316,795,500.00	309,470,961.52
210301	Гэрэл, цахилгаан	10,143,000.00	11,490,734.52
210302	Түлш, халаалт	254,795,600.00	248,136,000.00
210303	Цэвэр, бохир ус	51,856,900.00	49,844,227.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	320,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,566,000.00	9,799,500.00
210604	Урсгал засвар	10,566,000.00	9,799,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	148,882,100.00	109,947,276.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,198,700.00	63,578,162.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,683,400.00	46,369,114.47
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	163,163,100.00	47,964,432.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	141,081,500.00	26,223,332.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,081,600.00	21,741,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	119,679,400.00	114,602,800.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	119,679,400.00	114,602,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	119,679,400.00	114,602,800.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,440,400,100.00	<b>3,168,331,862.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,121,129,638.00	<b>2,849,061,400.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,121,129,638.00	2,849,061,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	319,270,462.00	319,270,462.00
132001	Орон нутгийн төсвөөс	319,270,462.00	319,270,462.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>144,399,978.39</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>119,204,664.55</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 279,019.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 181,975.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 3 алдааг<sup>1</sup> аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн, үр дүнгийн тайланд орлого буруу тусгасан 71,269.0 мянга,
- Мөнгөн хөрөнгийн тайланд орлого зөрүүтэй тусгасан 2,910.0 мянга,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого буруу тусгасан 107,796.7 мянган төгрөгийг тус тус залруулсан

Залруулагдаагүй 97,043.9 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 97,043.9 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс 18,783.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 78,260.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

## 5.1 Төлбөрийн акт

**5.1.1. Илрүүлэлт:** Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж тайлан баланст тусгаагүй 6,662.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцээгүй.

**5.1.2 Илрүүлэлт:** Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 12,120.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.2.1 Өртэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Санхүүгийн тайланд тусгаагдаагүй дулааны төлбөрийн өр санхүүжүүлж төлсөн, тухайн өр тооцоо нийлсэн акт баримт байхгүй 64,876.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан зөрчлийг давтан гаргахгүй байх,

## 5.2.2 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын цалингаас суутгасан орлогын албан татварыг төсвөөс илүү шилжүүлсэн 9,972.8 мянга, нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн 3,411.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг үнэн зөв хийж авлага үүсгэхгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүлээн авсан актаар баталгаажсан үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд дутуу бүртгэсэн, барилгын их засварын зардлыг дуусаагүй үйлдвэрлэлд бүртгээгүй	1	222.580.0	1	222.580.0			1	222.580.0	-	-
Санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан уялдаа холбоо үнэн зөв байдал зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	932.2	1	932.2			1	932.2		
Дүн	3	223.512.2	2	223.512.2			2	223.512.2		

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Заалны түрээсийн орлогын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж тайлан баланст тусгаагүй	1	6,662.7	1	6,662.7						
Сүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн санхүүжилтээс хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй	1	12,120.5	1	12,120.5						
Санхүүгийн тайланд тусгагдаагүй өр санхүүжүүлж төлсөн, тооцоо нийлсэн акт баримт байхгүй	1	64,876.7					1	64,876.7		
Ажилчдаас суутгасан хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төслөн	1	13,383.9					1	13,383.9		
	<b>4</b>	<b>97,043.8</b>	<b>2</b>	<b>18,783.2</b>			<b>2</b>	<b>78,260.6</b>		

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**